

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/041/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМАГ АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2024
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2025 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Шинжээч: Г.Жавзандолгор

Утас: 70272582 Цахим хаяг: javzandolgorge@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

᠒᠒᠗᠑.᠐᠒.᠒5 № ᠐1/᠒1
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Д.БАТЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Алтанбулаг сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол Алтанбулаг сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Тус байгууллага тайлант онд хөрөнгийн тооллогыг 2024.12.10-ны А/04 тоот тушаалаар томилогдсон ажлын хэсэг тооллого хийсэн ч ажлын хэсгийн илтгэх хуудаст үндсэн хөрөнгө 152,058.2 мянган төгрөгөөр зөрүүтэй, бараа материалын тооцоог нягтлан бодогч бодоогүй болон илтгэх хуудас байхгүй. Мөн өмч хамгаалах комиссын дүгнэлт байхгүй байна. Мөн өмнөх оны 22,000.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй, 32,044.9 мянган төгрөгийн өр төлбөр шинээр үүссэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээр санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Төв аймгийн Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь Тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу

412505375

67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн аймгийн Алтанбулаг сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллага юм.

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилт бүхий нийт 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 96,3 хувиар дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	129,000,864.0	125,233,864.0
33	АВЛАГА	22,000,000.0	22,000,000.0
335	Бусад авлага	22,000,000.0	22,000,000.0
3351	Байгууллагаас авах авлага	22,000,000.0	22,000,000.0
35	БАРАА МАТЕРИАЛ	107,000,864.0	103,233,864.0
351	Түүхий эд материал	17,000,000.0	12,000,000.0
35110	Тусгай зориулалттай материал	17,000,000.0	12,000,000.0
354	Хангамжийн материал	85,000,864.0	86,233,864.0
35420	Аж ахуйн материал	85,000,864.0	86,233,864.0
35600	Мал амьтад	5,000,000.0	5,000,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	9,263,213,639.5	<u>8,803,345,045.9</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	9,263,213,639.5	8,803,345,045.9
391	Газар	0.0	28,552,000.0
392	Биет хөрөнгө	9,206,035,639.5	8,736,818,045.9
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,995,718,280.4	2,311,502,315.4
39202	Хуримтлагдсан элэгдэл	-778,411,599.0	-897,340,062.6
39203	Авто-тээврийн хэрэгсэл	476,252,332.6	552,063,532.6
39204	Хуримтлагдсан элэгдэл	-244,454,024.3	-261,139,764.1
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	232,485,590.0	233,496,925.9
39206	Хуримтлагдсан элэгдэл	-141,018,924.4	-121,759,306.1
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	71,839,033.0	64,308,525.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-49,399,649.3	-20,222,317.4
39209	Зам, гүүрийн байгууламж	10,684,041,626.0	10,724,041,626.0
39210	Хуримтлагдсан элэгдэл	-3,300,011,447.8	-4,352,810,580.4
39214	Бусад үндсэн хөрөнгө	418,099,463.5	659,773,496.3
39215	Хуримтлагдсан элэгдэл	-180,923,241.2	-176,914,544.7
39217	Ном	21,818,200.0	21,818,200.0
393	Биет бус хөрөнгө	57,178,000.0	37,975,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	64,578,000.0	37,975,000.0
39304	Хуримтлагдсан элэгдэл	-7,400,000.0	0.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,392,214,503.5	8,928,578,909.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	32,044,888.5
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	32,044,888.5

413	Өглөг	0.0	32,044,888.5
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	236,511.1
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	31,808,377.4
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,392,214,503.5	8,896,534,021.5
51	Засгийн газрын хувь оролцоо	9,392,214,503.5	8,896,534,021.5
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	733,779,241.5	733,779,241.5
51101	Өмч: - төрийн	733,779,241.5	733,779,241.5
512	Хуримтлагдсан үр дүн	8,276,875,110.0	7,685,202,577.8
51210	Өмнөх үеийн үр дүн	8,276,875,110.0	8,276,970,314.6
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	-591,767,736.8
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	381,560,151.9	477,552,202.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,392,214,503.5	8,928,578,909.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,292,611,923.3	2,121,926,396.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	427,757,021.0	590,495,257.4
120	Нийтлэг татварын бус орлого	427,757,021.0	590,495,257.4
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	427,757,021.0	590,495,257.4
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		2,000,000.0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		446,933,983.4
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		141,561,273.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	864,854,902.3	1,531,431,139.5
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.0	1,195,294,600.0
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.0	1,195,294,600.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	106,589,402.3	336,136,539.5
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,842,982.0	308,426,539.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	47,746,420.3	27,710,000.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	758,265,500.0	0.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	758,265,500.0	0.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,158,345,793.4	2,572,132,860.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,994,953,633.4	2,569,986,360.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,960,105,300.6	2,272,100,138.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	459,146,271.2	638,249,011.3
210101	Үндсэн цалин	295,312,158.7	336,467,946.2

210102	Нэмэгдэл	102,422,113.2	213,904,752.8
210104	Урамшуулал	61,411,999.3	29,699,467.8
210105	Гэрээт ажлын хөлс	0.0	58,176,844.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	56,676,935.2	79,084,140.5
210201	Тэтгэврийн даатгал	38,211,919.8	54,556,258.5
210202	Тэтгэмжийн даатгал	4,643,854.2	5,910,756.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,715,083.3	3,142,324.2
210204	Ажилгүйдлийн даатгал	927,193.5	3,052,431.3
210205	Эрүүл мэндийн даатгал	9,178,884.4	12,422,369.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,657,446.7	93,390,605.4
210301	Гэрэл, цахилгаан	20,366,058.7	36,518,453.4
210302	Түлш, халаалт	54,991,388.0	55,872,152.0
210303	Цэвэр, бохир ус	300,000.0	1,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	42,161,076.0	59,610,018.0
210401	Бичиг хэрэг	3,043,300.0	3,308,500.0
210402	Тээвэр, шатахуун	30,802,376.0	46,887,328.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,683,000.0	2,513,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,632,400.0	1,286,190.0
210408	Бараа материал акталсны зардал	0.0	5,615,000.0
2105	Нормативт зардал	860,000.0	1,519,650.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	860,000.0	1,519,650.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,369,660.0	10,851,650.0
210604	Урсгал засвар	3,369,660.0	10,851,650.0
2107	Томилолт, зочны зардал	4,570,000.0	6,440,000.0
210702	Дотоод албан томилолт	4,570,000.0	6,440,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,295,013.0	20,939,042.25
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,322,000.0	15,121,192.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.0	1,612,800.0
210803	Даатгалын үйлчилгээ	318,375.0	384,964.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	522,638.0	598,200.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилогоо	132,000.0	304,800.0
210807	Газрын төлбөр	0.0	2,917,086.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,311,368,898.5	1,362,016,021.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	53,102,507.4	62,996,995.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,258,266,391.1	1,299,019,026.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	34,848,332.8	297,886,221.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,485,000.0	40,795,939.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.0	5,944,276.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	16,770,000.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	16,081,663.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,485,000.0	2,000,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.0	257,090,282.2
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	256,639,037.0
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	29,363,332.8	451,245.2
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	451,245.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	163,392,160.0	2,146,500.0
2200	Дотоод эх үүсвэрээр	163,392,160.0	2,146,500.0
220001	Барилга байгууламж	150,000,000.0	
221001	Их засвар	0.0	2,146,500.0
223001	Бусад хөрөнгө	13,392,160.0	0.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-865,733,870.1	-450,206,463.4

225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,549,232.7	141,561,273.4
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2,519,232.7	
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал – Үндсэн хөрөнгө	30,000.0	
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал – Бараа материал		141,561,273.4
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-2,549,232.7	-145,561,273.4
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-868,283,102.8	-591,767,736.8

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	864,854,902.3	1,533,431,139.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		2,000,000.0
122	Тусламжийн орлого		2,000,000.0
122001	Хандив тусламж /дотоод/		2,000,000.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	864,854,902.3	1,531,431,139.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	106,589,402.3	336,136,539.5
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	58,842,982.0	308,426,539.5
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	47,746,420.3	27,710,000.0
1320	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	758,265,500.0	1,195,294,600.0
132001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	758,265,500.0	1,195,294,600.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	757,465,747.3	1,266,504,058.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	757,465,747.3	1,266,504,058.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	718,817,414.5	967,954,112.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	457,809,085.4	637,605,841.8
210101	Үндсэн цалин	283,070,988.6	314,283,649.4
210102	Нэмэгдэл	118,944,567.6	254,992,064.1
210104	Урамшуулал	55,793,529.2	19,882,283.5
210105	Гэрээт ажлын хөлс		48,447,844.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.0	79,319,257.1
210201	Тэтгэврийн даатгал	57,948,773.4	55,910,383.5
210202	Тэтгэмжийн даатгал	39,398,281.3	5,718,969.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,637,623.1	3,078,297.6
210204	Ажилгүйдлийн даатгал	3,710,158.4	2,876,482.0
210205	Эрүүл мэндийн даатгал	927,464.6	11,735,124.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	75,657,446.7	93,300,000.0
210301	Гэрэл, цахилгаан	20,366,058.7	36,427,848.0
210302	Түлш, халаалт	54,991,388.0	55,872,152.0
210303	Цэвэр, бохир ус	300,000.0	1,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	38,818,100.0	51,998,400.0
210401	Бичиг хэрэг	3,159,300.0	3,152,500.0
210402	Тээвэр, шатахуун	17,260,600.0	37,296,400.0

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,743,000.0	2,669,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	15,655,200.0	8,880,500.0
2105	Нормативт зардал	1,300,000.0	1,353,400.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,300,000.0	1,353,400.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,599,660.0	1,321,028.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	80,000.0
210604	Урсгал засвар	3,599,660.0	1,241,028.0
2107	Томилолт, зочны зардал	4,394,000.0	6,440,000.0
210702	Дотоод албан томилолт	4,394,000.0	6,440,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,724,063.0	9,216,146.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,949,100.0	4,020,034.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	932,000.0	1,000,800.0
210803	Даатгалын үйлчилгээ	318,375.0	407,964.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	378,638.0	598,200.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	145,950.0	281,800.0
210807	Газрын төлбөр	0.0	2,907,348.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66,566,286.0	87,400,040.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,566,286.0	87,400,040.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,648,332.8	298,549,945.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,285,000.0	41,459,663.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.0	6,608,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	16,770,000.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	16,081,663.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,285,000.0	2,000,000.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	29,363,332.8	257,090,282.1
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	29,363,332.8	256,639,036.9
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		451,245.2
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	107,389,155.0	266,927,081.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	107,389,155.0	266,927,081.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	107,389,155.0	266,927,081.0
2200	Дотоод эх үүсвэрээр	107,389,155.0	
220001	Барилга байгууламж	0.0	
221001	Их засвар	0.0	
223001	Бусад хөрөнгө	30,545,255.0	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	76,843,900.0	266,927,081.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	733,779,241.5	381,560,151.9	9,145,158,212.8	10,260,497,606.3
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C08	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	733,779,241.5	381,560,151.9	9,145,158,212.8	10,260,497,606.3
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-868,283,102.8	-868,283,102.8
D03	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	733,779,241.5	381,560,151.9	8,276,875,110.0	9,392,214,503.5
D04	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	733,779,241.5	381,560,151.9	8,276,875,110.0	9,392,214,503.5
D05	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			95,204.6	95,204.6
D06	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	733,779,241.5	381,560,151.9	8,276,970,314.6	9,392,309,708.1
D07	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	95,992,050.2	0.00	95,992,050.2
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-591,767,736.8	-591,767,736.8
D09	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	733,779,241.5	477,552,202.1	7,685,202,577.80	8,896,534,021.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,195,294,600.0	1,075,888,542.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	935,294,600.0	897,808,773.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	909,916,600.0	872,430,773.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	605,345,700.0	576,345,515.3
210101	Үндсэн цалин	310,255,900.0	314,283,649.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.0	0.0
210104	Урамшуулал	27,304,500.0	19,882,283.5
210105	Гэрээт ажлын хөлс	63,659,100.0	46,787,248.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,668,400.0	72,010,377.8
210201	Тэтгэврийн даатгал	51,454,400.0	50,836,587.1
210202	Тэтгэмжийн даатгал	6,053,500.0	5,150,259.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,026,800.0	2,828,317.9
210204	Ажилгүйдлийн даатгал	3,026,800.0	2,596,119.2
210205	Эрүүл мэндийн даатгал	12,106,900.0	10,599,093.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,462,400.0	93,300,000.0
210301	Гэрэл, цахилгаан	37,063,000.0	36,427,848.
210302	Түлш, халаалт	55,899,400.0	55,872,152.00
210304	Байрны түрээс	0.0	0.0
2104	Хангамж, бараа материалын зардал	32,550,500.0	32,575,000.0
210401	Бичиг хэрэг	3,856,000.0	3,152,500.0
210402	Тээвэр, шатахуун	15,592,500.0	16,971,000.0
210404	Ном, хэвлэл	0.0	0.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	0.0	0.0

2105	Норматив зардал	0.0	1,353,400.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,353,600.0	1,353,400.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,500,000.0	12,487,828.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.0
210604	Урсгал засвар	10,000,000.0	9,987,828.0
2107	Томилолт, зочны зардал	0.0	5,590,000.00
210702	Дотоод албан томиллолт	0.0	5,590,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,738,000.0	13,446,112.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,250,000.0	8,250,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.0	1,000,800.0
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.0	407,964.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	600,000.0	598,200.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.0	0.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	69,408,000.0	65,322,540.0
213	Урсгал шилжүүлэг	0.	25,378,000.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.0	25,378,000.0
213205	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0.0	0.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.0	6,608,000.0
213207	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	0.0	16,770,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.0	2,000,000.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	260,000,000.0	178,079,769.0
2200	Дотоод эх үүсвэрээр	260,000,000.0	178,079,769.0
220001	Барилга байгууламж	100,000,000.0	98,179,109.0
222001	Их засвар	0	77,400,760.0
232001	Бусад хөрөнгө	0	2,499,900.0
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0	1,195,294,600.0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	1,195,294,600.0

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлагналтай холбоотой алдаа	4	250,951.8			4	250,951.8	3	36,859.3	1	214,092.7		
Дүн	4	250,951.8			4	250,951.8	34	36,859.3	1	214,092.7		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан	1	2,000.0	1	2,000.0								
Тооллогын илтгэх хуудас зөрүүтэй, тооцоо бодсон актгүй	1	152,058.2			1	152,058.2						
Цалингийн бичилт зөрүүтэй байна.	1	16,718.9					1	16,718.9				
Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй.	1	22,000.0			1	22,000.0						
Өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан ажиллаагүй байна.	1	31,954.3					1	31,954.3				
Орон нутагт тасралтгүй 5 жил буюу 60 сар ажилласан төрийн захиргааны албан хаагчдад олгосон мөнгөн урамшууллаас ХХОАТ суутгаагүй байна.	1	1,608.2	1	1,608.2								
Дүн	5	226,339.6	1	3,608.2	2	174,058.2	3	48,673.2	-	-	-	-